



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 540

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Говь-Сүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 2,786,299,183.00 (хоёр тэрбум долоон зуун наян зургаан сая хоёр зуун ерэн есөн мянга нэг зуун наян гурван) төгрөгийн үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг Говь-Сүмбэр аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Говь-Сүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 104,574,462.95 (нэг зуун дөрвөн сая таван зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун жаран хоёр төгрөг ерэн таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 18,235,119.00 (арван найман сая хоёр зуун гучин таван мянга нэг зуун арван есөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 дугаар хавсралтад заасан хөрөнгө (барилга)-ийг төрийн өмчид хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Говь-Сүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд болон тогтоолд заасан харьяа байгууллагын дарга болон Говь-Сүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх;

3.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*Д. Нарангэрэл*

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 4 дугаар сарын 28 ны өдрийн  
 540 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН БАГЦ) ЭЭР БАРЬСАН  
 ГОВЬ-СҮМБЭР АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (барилга байгууламж)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Ашиглагч байгууллага
				огноо	дугаар	
1	Конторын барилга (Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сум 2-р баг)	Тэнхлэгээрээ 18м х 30м хэмжээтэй, зорьтой, 3 давхар, цутгамал төмөр бетон үндсэн хийцтэй, бүрэн хийц, каркасан	2,389,260,108.00			
2	Дээвэр	Дээвэр (510 м2)	36,919,980.00			
3	Гадна зам талбай, явган зам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний явган зам (133 м) Жагсаалын талбай, явган зам, авто машины зогсоол (2804 м2)	187,758,885.00	2021.09.15	A/259	Говь-Сүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс
4	Гадна дулаан, цэвэр, бохир ус	Дулааны шугам (299.4м,) Цэвэр ус (73,2 м) Бохир ус (54 м)	140,923,530.00			
5	Цахилгааны шугам /кабель утас/	Гадна цахилгааны 0.4 кв, 3*120+70 мм 2, 420 м хос кабель	31,436,680.00			
	Нийт дүн		2,786,299,183.00			

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 4 дугаар сарын 22 ны өдрийн  
..... Дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ГОВЬ-СҮМБЭР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА  
ГОВЬ-СҮМБЭР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ЭЗЭМШҮҮЛЭХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон, дахин үнэлсэн он	Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Конторын барилга (Говь-Сүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг)	1971/2018	м2	407.38	81,332,131.32	14,625,514.67	66,706,616.65
2	Конторын өргөтгөл (Говь-Сүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг)	2004/2018	м2	100.56	23,242,331.63	3,609,604.33	19,632,727.30
Нийт дүн				507.94	104,574,462.95	18,235,119.00	86,339,343.95